



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Удирдах зөвлөл байгуулах тухай

Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолоор батлагдсан “Жендэрийн үндэсний хорооны дүрэм”-ийн 2.3, 2.9 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдлийг бэхжүүлэх, хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Төв Азийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хөтөлбөр” төслийн Монгол дахь Удирдах зөвлөлийг хавсралт ёсоор байгуулсугай.

2.Дор дурдсан чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг Удирдах зөвлөл /А.Ариунзаяа/-д чиглэл болгосугай. Үүнд:

2.1.Эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжихтэй холбогдсон хууль тогтоомжийг судлан, эерэг нөлөөлөл үзүүлэх, бодит үр дүн гаргах зохицуулалт бүхий хуулийн төсөл боловсруулах;

2.2.Бодлогын шийдвэр, хөтөлбөрт жендэрээр ангилсан мэдээллийн санг бий болгож, холбогдох байгууллагуудад мэдээлэл бүрдүүлэх ажлыг тогтмол системтэйгээр хийж гүйцэтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;


2.3.Санхүүгийн болон бизнес эрхлэлтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэгийг бодитой, үр дүнтэй болгож, бодлогын зураглал гарган бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан хөтөлбөрүүд бий болгох.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, Удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, зохион байгуулалтаар ханган, ажлын явц, үр дүнг жил бүр Хорооны хуралдаанд тайлагнаж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Т.Энхбаяр/-т даалгасугай.

ДАРГА



Л.ОЮУН-ЭРДЭНЭ



Жендэрийн үндэсний хорооны
2021 оны 6-у дугаар сарын 07-ний
өдрийн 04-дугаар тогтоолын хавсралт

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа
- Дэд дарга: Жендэрийн үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаяр
- Гишүүд: Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн бүлгийн дарга Д.Сарангэрэл (зөвшилцсөнөөр)
- Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа
- Санхүүгийн зохицуулах хорооны Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга Ц.Алтантуул
- Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтын газрын дарга И.Батхүү
- Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга М.Өлзийбат
- Жижиг, дунд үйлдвэрийн газрын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга А.Гэрэлзаяа
- Монгол банкны Судалгаа, статистикийн газрын ахлах эдийн засагч Д.Цэнддорж
- Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч Б.Оюунгэрэл
- Монголын ноос ноолуурын холбооны гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг
- Монголын оёдлын холбооны тэргүүн Д.Тучгалаг
- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Мөнхзул
- Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооны дэд тэргүүн Ц.Алтантуяа
- Монголын хүнсчдийн холбооны мэргэжилтэн Э.Ариунаа
- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн ментор клуб ТББ -ын Гүйцэтгэх захирал Э.Уянга

Эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн захирал
Б.Түвшинтөгс

Австралийн элчин сайдын яамны Гадаад харилцаа
худалдааны газрын Нэгдүгээр нарийн бичгийн дарга
Дэвид Престон(зөвшилцсөнөөр)

Европын Холбооны Монгол дахь төлөөлөгчийн газрын
хөтөлбөрийн менежер Э.Болор(зөвшилцсөнөөр)

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгч Илейн
Конкиевич(зөвшилцсөнөөр)

Азийн хөгжлийн банкны Нийгмийн хөгжлийн ахлах
мэргэжилтэн /Жендэр/ Б.Цолмон(зөвшилцсөнөөр)

Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн
Хөтөлбөрийн менежер Жутта Рехаг(зөвшилцсөнөөр)

Дэлхийн Банк/Олон улсын санхүүгийн корпорацийн
Гадаад хөрөнгө оруулалтын бодлого төслийн удирдагч
Д. Жигжидмаа(зөвшилцсөнөөр)

Европын сэргээн босголт хөгжлийн банкны Жижиг
бизнесийн зөвлөх хэлтсийн тэргүүлэх менежер
С.Байгалмаа(зөвшилцсөнөөр)

Канад Улсын Хөгжлийн Агентлагийн Элчин зөвлөх,
Хөгжлийн хөтөлбөрийн тэргүүн Глен
Зизански(зөвшилцсөнөөр)

КОЙКА (БНСУ-ын Олон улсын хөгжлийн байгууллага)-ын
суурин төлөөлөгч Жу Хэйн-Нан(зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн
дарга:

Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны Гадаад
харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн
Ц.Нандинтүшиг

Европын сэргээн босголт хөгжлийн банкны Монгол Улс
дахь суурин төлөөлөгчийн газрын төсөл хариуцсан
ажилтан.